

ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН
2023



АГУУЛГА

УДИРДЛАГЫН ҮҮРЭГ АМЛАЛТ

- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ 3
- Гүйцэтгэх захирлын мэндчилгээ 4
- Группийн тухай 5

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО, АЛСЫН ХАРАА

- Тогтвортой хөгжлийн стратеги 6-8

ТОГТВОРТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Байгаль орчин
 - Эрчим хүч 10
 - Хог хаягдал 11
 - Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал 12
- Нийгэм
 - Тогтвортой ажлын байр 14
 - Сургалт, хөгжил чадавх бэхжүүлэх 15-16
 - Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй 17
 - Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа 18-25
- Засаглал
 - Авлига ёс зүй 26





ТЭСО Групп нь тогтвортой хөгжлийг баримтлан, хамтын үнэ цэнийг бүтээн, дэлхийд өрсөлдөх алсын харааг чиглэн, гучаад жилийн түүхийг бий болгосоор өдгөө 2000 гаруй ажилтантайгаар Монгол Улсын тэргүүлэх үйлдвэрлэгчдийн нэг болон өргөжсөөр байна.

Бидний хувьд анх бизнесээ эхлүүлэхдээ Монгол хүн монголдоо эрүүл хүнсийг хэрэглэх, нөгөө талаас бидний сэргээгдэх баялаг болох мал аж ахуй, цагаан идээгээр дамжуулан малчдад үнэ цэнийг бий болгох хэрэгцээнд тулгуурлан бизнесийн эхлэлээ тавьсан билээ. Сэргээгдэх баялаг нь байгальд болон хүнд ээлтэй гэдгээрээ онцлог байдаг. Энэ утгаараа

тухайн онцлогийг орчин үеийн дэвшилтэт технологи, инновацыг ашиглан, гаргасан эрүүл мэндэд ээлтэй бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах, барилга бүтээн байгуулалт, бизнесийн хөрөнгө оруулалтын бүхий л үйл явцад тогтвортой хөгжил оршдог юм. Бизнесийн хувьд бид цаашид ч мөн адил байгаль орчин, нийгэм, эдийн засагтаа хор нөлөөгүй бизнесүүдэд хөрөнгө оруулалт хийх замаар хувь нэмрээ оруулан ажиллана.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс цаашид Тогтвортой хөгжил болон БОНЗ-ыг стратегийг менежментийн түвшинд шингээж, энэ чиглэлийн санал санаачилгыг дэмжин ажиллахаа илэрхийлж байна. ТЭСО Группийн ажилтан бүр

тогтвортой хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулж, салбартаа мэргэшиж, цаг үетэйгээ хөл нийлүүлэн, тасралтгүй суралцаж, хөгжих замаар сайхан ирээдүйг хамтын үнэ цэнээр бүтээнэ гэдэгт итгэлтэй байна.

Богино хугацаанд томоохон компани болоход бус урт хугацаандаа тогтвортой хөгжсөн компанийг бий болгож, эдийн засгийн хувьд тогтвортой улс орныг төлөвшүүлэх алсын харааг өвөртлөн ажиллаж буй бидний замналтай танилцаж буйд талархал илэрхийлье.



**Хүндэтгэсэн,
О.Дамжин**

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



САЙН БАЙНА УУ,

Нийт хэрэглэгч, харилцагч, хамтран ажиллагч байгууллагууд, ТЭСО Группийн түүхийг хамтдаа бичилцэж буй ажилтнууддаа тогтвортой хөгжлийн тайланг танилцуулж байгаадаа таатай байна. Бид Тогтвортой хөгжлийн тайланг олон нийтэд нээлттэй байдлаар анх удаа тайлагнаж байгаа бөгөөд бидний хувьд 2023 он нийгмийн хариуцлага тэр дундаа боловсрол, хүүхэд гэсэн үндсэн чиглэлд арвин ажил хийсэн, энэ хүрээнд хамтын ажиллагаагаа нэмэгдүүлсэн, хамтын үнэ цэнийг бүтээсэн амжилттай жил байлаа.

ТЭСО Группийн хувьд
Тогтвортой хөгжилд хамтын үнэ

цэнээр дэлхийд өрсөлдөх эрхэм зорилгыг тавьж тайлант жилд тогтвортой хөгжлийн нэгдсэн бодлогыг шинэчлэн баталсан бөгөөд энэ хүрээнд хүнсний үйлдвэрлэл, барилга бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагт чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр байна. Бодлогын дагуу хэрэглэгч, ажилтан, нийлүүлэгчдийн дунд зохистой хөдөлмөрийг бий болгох, бүгдэд ээлтэй нийгмийг бүтээхэд хувь нэмрээ оруулах, хүний эрхийн зөрчлийн оролцогч тал болохгүй байхад чиглэсэн төсөл хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Бидний зүгээс бүхий л салбартаа эрчим хүч, хог хаягдлыг дахин

боловсруулах, ялгах хэвшлийг хамт олондоо суулгахад арга хэмжээ авч, ашиг сонирхлоос ангид байх хүрээнд компанийн хэмжээнд “Шүгэл үлээх” механизмыг хэрэгжүүлэн ажилладаг.

Ирээдүйн сайн сайхны төлөө, урт хугацааны тогтвортой хөгжлийн чиглэлд хийгдсэн байгаль орчин, нийгэм, засаглал, эдийн засгийн хүрээний ажлын үр дүн, санаачилгатай танилцана уу.

**Хүндэтгэсэн,
Сайнжаргалын Болор**
Гүйцэтгэх захирал



ТЭСО Групп нь 2003 онд хүнсний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр бизнесийн үйл ажиллагаагаа эхлүүлсэн бөгөөд өдгөө барилга бүтээн байгуулалт, үл хөдлөх хөрөнгийн менежмент, санхүү, хөрөнгө оруулалт, гадаад худалдаа, экспорт, аялал жуулчлал, зочлох үйлчилгээ зэрэг бизнесийн голлох чиглэлүүдэд нийт 30 салбар болон хамтарсан компанитай болон өргөжжээ.

Бид зах зээлийн өрсөлдөөнд ялгарал бий болгох, шинэлэг бүтээгдэхүүн гаргахад анхаарч, инновацад тулгуурлан өргөжин, дэвшсээр байна. Дотоодын хүнсний зах зээлийг чанартай, эрүүл болгоход хувь нэмрээ оруулаад зогсохгүй, Монголын уламжлалт хүнсэнд инновацыг шингээн, экспортод гаргадаг болсон билээ. ТЭСО Групп нь хүнсний экспортын чиглэлээр сүүлийн 5 жилийн турш улсдаа тэргүүлэн, өндөр үзүүлэлттэй ажиллаж, барилга бүтээн байгуулалт, барилгын материал үйлдвэрлэл зэргээр бизнесийн цар хүрээг тэлж, томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг хэрэгжүүлээ.

Бизнесээ эхлүүлсэн цагаас нийгэмд ээлтэй, сайн сайхныг эрхэмлэн ажиллаж байна. Бодлого хэрэгжүүлэх, бизнесийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн эко системийг бий болгож, хүнс, аялал жуулчлалын салбарын экспортоор эдийн засгаа солонгоруулахыг зэрэгцээ хүн бүрд ээлтэй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилтыг тавин ажиллаж байна.



ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО АЛСЫН ХАРАА

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

ТЭСО Группийн салбар компаниуд НҮБ-ын “Даян дэлхийн гэрээ”-нд үүрэг, амлалт хүлээн нэгдэн орохоор зэхэж, бизнес ба хүний эрхийн зарчим, шаардлагуудыг компанийн менежментийн үйл ажиллагаанаас эхлэн өдөр тутмын үйл ажиллагаанд шат дараалан нэвтрүүлэн ажиллаж байна.



Бидний хувьд өнгөрсөн 25 гаруй жилийн хугацаанд эрхэлж буй бүхий л бизнесээ байгаль орчин, нийгэмд ээлтэй эсэхийг нягтлан, шийдвэр гаргалтыг хийж, ажиллаж байна. ТЭСО Групп нь байгаль орчин, нийгмийн эсрэг бизнест хөрөнгө оруулахгүйгээр татгалзах, цаашлаад хүний эрхийн зөрчлийн оролцогч тал болохгүй байх нөхцөлийг анхааран ажилладаг.

Тайлант онд Тогтвортой хөгжлийн бодлогыг шинэчлэн баталсан бөгөөд бид хүүхдийн сайн сайхны төлөө болон боловсролд хөрөнгө оруулах замаар тогтвортой нийгмийг бүтээхээр зорьж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ



АЖИЛТАН-ХЭРЭГЛЭГЧ-ХАРИЛЦАГЧДАД ЭЭЛТЭЙ, ИЛ ТОД ЗАСАГЛАЛЫГ БҮРДҮҮЛЭХ

Хүний эрхийг дээдэлж, олон янзат байдал, хүртээмжтэй орчныг бий болгох

Сургалт, хөгжил, чадавхыг бэхжүүлэх

Хөдөлмөрийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх

Ил тод бизнесийн гинжин хэлхээний бүх шатанд хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байх




БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ СӨРӨГ НӨЛӨӨГҮЙ

Эрчим хүчний хэмнэлтийг бий болгох

Зөв зохистой менежментийг хэрэгжүүлэх, хэрэглээг бууруулах

Усны хэрэглээг бууруулах, дахин ашиглах, хэмнэх

Түүхий эд материалыг зөв зохистой ашиглах



НИЙГЭМД ЭЭЛТЭЙ, ЁС ЗҮЙТЭЙ БИЗНЕСИЙН ОРОН ЗАЙГ БҮРДҮҮЛЭХ

Бизнесийн ёс зүйтэй, нээлттэй засаглалыг бий болгох

Оролцогч талуудын хамтын ажиллагаа, хамтын оролцоотой үйл ажиллагаа эрхлэх

Эрсдэл, нийцлийн удирдлагыг хэрэгжүүлэх

БАЙГАЛЬ ОРЧИН

Эрчим хүч	10
Хог хаягдал	11
Уур амьсгалын өөрчлөлт ба хүлэмжийн хийн ялгарал	12





Эрчим хүчний хэрэглээ, хаягдал ус, хогийг үйлдвэрлэлээс байгаль орчин түүний нөөцөд нөлөөлж буй нөлөөллүүдийг бууруулах, хамгийн бага хэмжээнд байлгахад анхааран ажилласан. Үр дүнд нь **Эрчим хүчний менежментийн тогтолцоо ISO 50001:2015** стандартыг мөн хаягдал ус, хогийн менежментийг сайжруулах **Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015** стандартыг 2021 онд тус тус нэвтрүүлэн ажиллаж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ МЕНЕЖМЕНТ

ТЭСО Фүүдс, ТЭСО Пропертис компаниуд эрчим хүчний үүрэг хүлээсэн хэрэглэгчийн хувьд Эрчим хүчний тухай хууль, холбогдох журмуудын дагуу аудит хийж, менежментийн төлөвлөгөөг тогтмол боловсруулан, холбогдох байгууллагад тайлагнан ажилладаг.



2023 оны байдлаар эрчим хүчийг

42,617 квт/ц-аар хэмнэн ажилласан.



ХОГ ХАЯГДАЛ

Үйл ажиллагаанаас үүссэн энгийн болон аюултай хог хаягдлыг зориулалтын дагуу боловсруулдаг.

Компаниудын үйл ажиллагаанаас үүссэн **65** тонн энгийн хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт өгч, **352** тонн хог хаягдлыг зориулалтын дагуу гэрээт байгууллагуудаар устгуулсан.



2023 онд нийт аюултай хог хаягдал болох дугуй болон

800 литр

тос тосолгоог зориулалтын саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлсэн

Хог хаягдлын менежментийн хувьд

БОМТ 14001:2016

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний шаардлага болон БОМТ-ний дагуу агаарын орчин, хөрсний орчин, бохир уснаас тодорхой давтамжийн дагуу шинжилгээ, мониторинг хийж ажиллаж байна.



УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ХҮЛЭМЖИЙН ХИЙ



ТЭСО Группийн бүх салбар компаниуд нь Монгол Улсын хууль тогтоомж, байгаль орчны ерөнхий үнэлгээ, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний шаардлагуудыг дагаж мөрдөн, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн зэрэгцээ харилцагч Азийн хөгжлийн банкны “Хамгаалалтын бодлого, журам” түүний “Байгаль орчин нийгмийн удирдлагад үйл ажиллагаагаа нийцүүлэх, олон улсын стандарт”-д хүрэхээр чиглэн ажилладаг.

НИЙГЭМ

Тогтвортой ажлын байр	14
Сургалт, хөгжил чадавх бэхжүүлэх	15-16
Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй	17
Нийгмийн хариуцлага ба хамтын ажиллагаа	18-25

ТОГТВОРТОЙ АЖЛЫН БАЙР

2023 оны үзүүлэлт



Хүний хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд нийт **1 тэрбум 420 сая** төгрөгийг зарцуулжээ.

Ажилтны сэтгэл ханамж

Нийт ажилтны сэтгэл ханамжийн судалгаагаар тайлант онд өмнөх оноос 3 хувиар өссөн байна

ТЭСО Групп нь Хүний нөөцийн бодлого, хөгжилдөө үнэт зүйлээ **“Алхам алхмаар хамтын үнэ цэн бүтээх”** хэмээх үзэл баримтлалаар нийт ажилтнууддаа бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, оновчтой, үр ашигтай, олон талт хөдөлмөрийн харилцааг бие болгосноор ажлын байрны орчин харилцаанд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, хууль дүрмийг баримтлан ажилладаг төдийгүй, Олон Улсын болон НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудыг бизнесийн талбар бүртээ хэрэгжүүлэн ажиллахыг зорьж байна.

ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- Сонгон шалгаруулалтад ижил тэгш боломжийг олгох;
- Хүйсийн харьцааг тэгш байлгах;
- Ажлын байранд үл ялгаварлал, нээлттэй харилцааг бий болгох;
- Бие, сэтгэл зүй, бэлгийн аливаа дарамт хүчирхийллээс ангид байх;
- Өрсөлдөхүйц цалин хөлс, хангамжийг олгох;
- Өөрчлөлт, сорилтод нээлттэй, суралцагч соёлыг төлөвшүүлэх;


СУРГАЛТ ХӨГЖИЛ

ТЭСО Групп тайлант онд ажилтнуудынхаа чадавхыг бэхжүүлэх албан болон албан бус сургалтуудыг зохион байгуулахад нийт 1 тэрбум гаруй төгрөг зориулжээ.

ТЭСО Группийн салбар компани тус бүрийн үйл ажиллагааны онцлогт тохируулсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, ажилтны хөгжлийн тусгай хөтөлбөрийг хэрэгжүүлж байна



ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2023 ОНД





СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



СУРГАЛТ ХӨГЖИЛ

Өнгөрсөн онтой харьцуулахад
Зохион байгуулсан сургалтын тоо

70.8% -р өсөж



Сургалтад зарцуулсан нийт цаг

“ТЭСО АКАДЕМИ”-Н ДОТООД СУРГАГЧ БАГШ НАР:

Ажилтны хандлага, ур чадварыг дотоод сургалт, хөтөлбөрөөр дамжуулан хөгжүүлж, түлхүүр ажилтныг тогтвортой хадгалах, түлхүүр ажлын байрны залгамж халааг бэлтгэх, нийт ажилтнуудын ажлын байран дээрээ өсөж хөгжих хэрэгцээг бүрдүүлэх, тасралтгүй суралцах соёлыг бий болгох зорилгоор 2020 онд “ТЭСО АКАДЕМИ” -ийг байгуулан өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. ТЭСО Группийн богино болон урт хугацааны стратеги, бизнес хөгжлийн төлөвлөгөөний дагуу Бид жил бүр системтэйгээр багш нараа бэлтгэн, сургалтын хөтөлбөрөө Олон Улсын стандартад нийцүүлэн мэргэжлийн болон зөөлөн ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр мэргэжлийн зөвлөх байгууллагуудтай хамтран боловсруулан улам төгөлдөржүүлэн ажиллаж байна.



52

Сургагч багшийн
тоо

364

Нийт сургалтын
тоо

546

Нийт сургалтын
цаг

7280

Нийт хамрагдсан
ажилтан
/давхардсан тоогоор/

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Үзүүлэлт	ТЭСО Фүүдс	ТЭСО Пропертис
ХАБЭА-н сургалт, зааварчилгаанд хамрагдсан ажилтны тоо (давхардсан тоогоор)	3590	2274
ХАБЭА-н сургалтад зарцуулсан нийт дүн	3,133,500	15,665,000
ХАБЭА, БО-ы хүрээнд зарцуулсан нийт дүн	317,522,321	252,193,590

“ТЭСО Фүүдс” ХХК-ийн эрсдэлийн менежментийн хүрээнд 2023 онд нийт 62 ажлын байрны 905 ажилбарт эрсдэлийг үнэлж, өндөр эрсдэлтэй 234 ажилбарыг тодорхойлж, эрсдэл бууруулах, сайжруулах ажил хийснээр өндөр эрсдэлтэй ажилбарыг 79% бууруулсан байна. Түүнчлэн галын аюулгүй байдлын үзлэгийг тогтмол хийж, нийт ажилтнууддаа урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах сургалт, сургуулилтыг тогтмол хийдэг. “ТЭСО Фүүдс” ХХК-ийн 6 үйлдвэрийн барилга, байгууламжид Галын аюулгүй байдлын үзлэгийг “Евро Ази Сервис” ХХК-иар хийлгэж, үндсэн 14 зөрчлийг бүртгэж, тэдгээрийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.



ОЛОН ЯНЗАТ БАЙДАЛД ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЗӨВ БАГАЧУУД ЦЭЦЭРЛЭГ

Байгууллага бүр ажилтан, ажилтны гэр бүлийн амьдралын сайн сайхан байдлыг хангах үүргийг хүлээдэг. Ажилтнуудын дунд явуулсан сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн 2019 онд “Зөв багачууд” цэцэрлэгийг байгуулсан. Уг цэцэрлэг ашиглалтад орсноор ажилтнууд хүүхдээ ойрхон, тав тухтай цэцэрлэгт өгч, өглөө орой тайвнаар ажлаа төлөвлөн, бүтээмжтэй ажлаа хийж, хүүхдээ эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжүүлэх боломжтой болсон юм.

Зөв багачууд цэцэрлэг 2023-2024 оны хичээлийн жилд 20 багш, ажилтан, 5 бүлгийн 165 хүүхэдтэйгээр сургалт, хүмүүжил, хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.



ОЛОН ЯНЗАТ БАЙДАЛД ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛД БЭЛТГЭХ “SPARK DAY” ХӨТӨЛБӨР

ТЭСО Группийн хувьд оюутан, залуусын “entrepreneur” санаачилга, бүтээлч сэтгэлгээг дэмжих хөтөлбөрүүдийг тогтмол хэрэгжүүлдэг. Үүний нэг нь “SPARK DAY” төслийн уралдаан юм. Бидний хувьд “SPARK DAY” төслийн уралдааныг 2022 оноос эхлэн тасралтгүй зохион байгуулсан бөгөөд уралдаанд оролцож буй залуус нэг сарын хугацаанд багаар ажиллан, өөрсдийн төслийн саналыг боловсруулахдаа зөвлөхүүдээс дэмжлэг, зөвлөгөө авч, эцсийн төслийг бэлтгэн танилцуулдаг. Танилцуулсан төслөөс шилдэг санал санаачилга гаргасан багуудаас шалгаруулан, цаашид дэмжих зорилгоор Эүүн өмнөд Азийн шилдэг гарааны бизнес, хөрөнгө оруулагч, үүсгэн байгуулагчид хуран чуулдаг “Techsauce Global Summit” арга хэмжээ, Бүгд Найрамдах Казакстан Улс руу аялан “Astana Hub”-д зочилж, “Global Bridge” арга хэмжээнд оролцох эрхийг олгох зэрэг бусад орны сайн туршлагаас тасралтгүй суралцах орон зайг бүрдүүлэн ажилласаар байна.




ИРГЭД ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



“Engineers of The Future”

“ТЭСО Пропертис Групп”-ийн зүгээс Ирээдүйд инженер болох залуучуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, дэмжих зорилгоор барилгын чиглэлээр суралцаж буй оюутнуудын дунд “Engineers of The Future” хөтөлбөрийг зарлаж амжилттай хэрэгжүүллээ.

БОЛОВСРОЛ ТЕХНОЛОГИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР



“TOMYO&TESO”

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд Монгол оюуныг Дэлхийд хүргэх зорилготой “Tomyo” технологийн компанитай хамтран, “Tomyo Talk-2023” арга хэмжээг зохион байгуулсан. Энэ хүрээнд залууст энтертайнмент үйл ажиллагаа болон илтгэл тавих хэлбэрээр дамжуулан залууст боловсрол, нийгмийн ойлголтуудыг өгөх, урам зоригийг бий болгоход чиглэн ажиллаа.

ИРГЭД ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЭЕШ “Амжилт” хөтөлбөр

Нийгмийн хариуцлагын хүрээнд бид ЭЕШ өгч буй сурагчдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх зорилготой сүүлийн хоёр жилийн хугацаанд “Айсмарк” ХХК нь “Амжилт” хөтөлбөрийг зохион байгуулж байна. Энэ хүрээнд бид Улаанбаатар хотын 12 сургуулийн ойролцоо газар 10,000 гаруй зайрмаг үнэгүй тараасан бөгөөд урлагийн олон артистууд нэгдэж дэмжлэг үзүүлж, “УВСАВ” сурагчдыг үнэ төлбөргүй сургуульд нь хүргэж өгөх байдлаар хамтран оролцсон байна.

Мөн хөтөлбөрийн хүрээнд бид ЭЕШ өгсөн хүүхдүүдээс 800 оноо авсан 159 хүүхдүүдийг үйлдвэрийн байранд хүлээн авсан. Уг арга хэмжээгээр сурагчдад ирээдүйд нийгэмд олон зүйлийг цогцлоох хүсэл зорилго, тэмүүлэлтэй болгох, Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулах боломжтойг ойлгуулах зорилготой арга хэмжээ болсон.

БОЛОВСРОЛ ТЕХНОЛОГИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР



ИРГЭД ОЛОН НИЙТ, НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хүүхэд залуучуудын спортын боловсролыг дэмжих, тэдний сурч боловсрох, чөлөөт цагаа үр дүнтэй зөв өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд АНУ-ын мэргэжлийн сагсан бөмбөгийн /NBA/ шууд дамжуулалтын ерөнхий ивээн тэтгэгчээр 3 дахь жилдээ хамтран ажиллаж байна.

НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР

Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд залуучуудын спортын боловсролын дэмжих тэдний сурч боловсрох, чөлөөт цагаа үр дүнтэй зөв өнгөрүүлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “Хасын хүлгүүд” сагсан бөмбөгийн багийг дэмжин, хамтран ажиллаж байна.




НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

UNICEF

НҮБ-ын Хүүхдийн Сан болон ТЭСО Групп нь 2023 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг үзэглэлээ. Энэ хүрээнд хүүхдийн эрх, бизнесийн зарчим дээр, гэр бүлд ээлтэй ажлын байрны бодлогыг сурталчлахад, хөдөө орон нутгийн хүүхдүүдийн боловсролыг дэмжихэд чиглэсэн хамтын ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА



EMPASOFT

Хөгжлийн гол шийдэл болох боловсрол технологид чиглэсэн “Эмпасофт технологийн их сургууль” 500 сая төгрөгийн нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалт хийсэн. Энэ хүрээнд алслагдсан аймаг, сумдад байгаа хүүхдүүдэд мэргэжил таниулах, боловсролын орчин дахь тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг тасралтгүй хийж гүйцэтгэж байна.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА БА ХАМТЫН АЖИЛЛАГАА

GURUN ACADEMY

“Gurun Academy”-ийн санаачлан, хэрэгжүүлж буй Ерөнхий боловсролын сургуулийн 400 мянган сурагчдын англи хэлний бичгийн болон ярианы түвшинг сайжруулах төслийг Тогтвортой хөгжлийг эрхэмлэгч ТЭСО Групп дэмжин ажиллаж байгаа бөгөөд тайлант онд төслийн нэгдүгээр шатны ажил амжилттай хэрэгжлээ. Энэ хүрээнд Монгол Улсын хэмжээнд “Astrid” аппликейшн дээр тулгуурласан 1908 англи хэлний цахим анги үүсэж, сурагчид идэвхтэйгээр ашигласаар байна.



ЗАСАГЛАЛ

ЁС ЗҮЙ

ЁС ЗҮЙ

ТЭСО Групп нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх бодлогыг бүхий л шатанд баримтлан ажилладаг. Группийн хэмжээнд дараах үндсэн зарчмын хүрээнд бодлого, журмыг батлан мөрддөг.



АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙХ

ТЭСО Групп нь гэрээ хэлэлцээр байгуулах, худалдан авалт хийх, ажилтныг сонгон шалгаруулах зэрэг харилцаанд бусдад зүй бус давуу байдал үүсгэх эсхүл бусдын эрх ашгийг хохироох үйлдлийг ямагт хүлээн зөвшөөрөхгүй. Холбогдох хууль тогтоомж, дотоод хэм хэмжээг ягштал мөрдөн, ил тод шударгаар үйл ажиллагаагаа явуулахыг эрхэмлэдэг.

ТЭСО Группийн Ёс зүйн дүрэм, дотоод хэм хэмжээнд заасны дагуу ажилтан ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, хууль бус мөнгөн орлого, зээл, тусламж, үйлчилгээг харилцаг, үйлчлүүлэгчээс хүлээн авахаас татгалзах, тухайн нөхцөл байдал үүссэн бол компанид мэдэгдэх үүрэг хүлээдэг.

ШҮГЭЛ ҮЛЭЭХ

ТЭСО Групп нь нийт ажилтнуудын болон компанийн эрх ашгийг хохироож болзошгүй эсхүл хохироосон хууль бус, ёс зүйгүй үйлдлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, улмаар компанид эрүүл, аюулгүй орчин, соёлыг төлөвшүүлэх зорилгоор “Шүгэл үлээх” тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. ТЭСО Группийн ажилтан нь Монгол Улсын хууль тогтоомж болон Группийн дотоод хэм хэмжээг зөрчсөн бол тухайн зүй бус үйлдэл, эс үйлдэхүйг олж мэдсэн хүн шүгэл үлээх журмын дагуу мэдээлэх боломжтой. Бид шүгэл үлээх журмын дагуу шүгэл үлээгчийн ирүүлсэн мэдээлэл болон түүний хувийн мэдээллийг найдвартай нууцлан, журмын дагуу холбогдох арга хэмжээг шуурхай авч ажилладаг.

Бид группийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх санал, хүсэлтийг мэргэжлийн гуравдагч байгууллага болох **CENTRIC FRONT LINE SERVICE** компаниар гүйцэтгүүлэн хэрэглэгч харилцагчтайгаа байнгын эргэх холбоотой ажилладаг.






ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



ХАМТЫН ҮНЭ ЦЭН



ДЭЛХИЙД ТҮҮЧЭЭЛНЭ

The logo for TESO Group is centered on a blue background. It features the word "TESO" in a large, bold, white sans-serif font. A white swoosh underline is positioned under the "E" and "S". Below "TESO", the word "Group" is written in a smaller, white sans-serif font. The background includes a grid of light blue lines with circular nodes, a large semi-transparent circle behind the text, and a bright blue sphere in the top right corner.

TESO
Group